

## ХИЛИЙН БООМТЫН СЭРГЭЛТИЙН БОДЛОГО УЛСЫН ХИЛИЙН ОРОН ЗАЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

### Х.БАЯСГАЛАН

ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн эрхлэгч, удирдахуйн ухааны магистр, хурандаа

**Товч агуулга:** Монгол Улсын хилийн орон зайн хөгжилд хилийн боомтын сэргэлтийн үзүүлэх нөлөөллийн тухай өгүүлэх болно.

**Түлхүүр үгс:** Улсын хил, хилийн орон зай, хилийн боомт, шалган нэвтрүүлэх алба, шинэ сэргэлтийн бодлого, эдийн засаг, хөгжил.

### Оршил

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа Шинэ сэргэлтийн бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст / КОВИД-19-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм. Өнөөдөр цар тахал үндсэндээ хумигдсан ч дэлхий нийтэд шинэ сорилтыг бий болгосон онцлогтой. Энэхүү цаг үед Монгол Улс дэлхий нийттэй харилцах гол үүд хаалга нь хилийн боомт гэдгийг тодорхойлон Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичигтээ 6 сэргэлтийг тусган хилийн боомтын сэргэлтийг нэгдүгээрт эрэмбэлсэн нь улсын хилийн орон зайд хөгжил дэвшил ирэх таатай нөхцлийг бүрдүүллээ.

### Үндсэн хэсэг

Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин

65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө гэж тооцоолж байна. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ. Бодлогын хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж байгаа 6 багц асуудлыг шийдвэрлэх болно. Үүнд:

Нэг. Боомтын сэргэлт;

Хоёр. Эрчим хүчний сэргэлт;

Гурав. Аж үйлдвэржилтийн сэргэлт;

Дөрөв. Хот хөдөөгийн сэргэлт;

Тав. Ногоон хөгжлийн сэргэлт;

Зургаа. Төрийн бүтээмжийн сэргэлт.

Улс орны хөгжлийн тулгамдсан асуудлын нэгдүгээрт хилийн боомтын сэргэлтийн асуудал яригдаж байгаа нь хилийн хяналтын байгууллагууд, тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн засаг захиргаа, байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдийн харилцан уялдсан ирээдүйн хөгжлийн том зураг дэлгэгдэж, гарц гарч байна гэж харах үндэслэлтэй.

“Боомтын сэргэлтийн асуудалд:

1.1.Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон

зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

1.2.Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3.Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттайгаар үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.

1.4.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ”<sup>1</sup> гэж заасан байна.

Хил хамгаалах байгууллага нь “Монгол Улсын хилийн тухай хууль”-ийн дагуу улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг 2017.02.01-ний өдрөөс дахин хэрэгжүүлж эхэлсэн. Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын хилийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах, дэг журмыг сахиулах зорилгоор тухайн боомтод мөрдөх журмыг хэрэгжүүлэх, ерөнхий зохицуулалтаар хангах, хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхолыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно”<sup>2</sup> гэж эдийн засгийн хамаарлын талаар тусгасан. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс, хамтарсан буюу гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай аж ахуйн томоохон нэгж байгуулах, концесс олгох, дэд бүтэц шинээр бий болгох зэрэг эдийн засгийн хөгжилд үлэмж нөлөө үзүүлэх төсөл, арга хэмжээг үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцүүлэн хэрэгжүүлнэ.”<sup>3</sup>

Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлогод “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах”,<sup>4</sup> гэсэн эдийн засагтай холбоотой заалтууд тусгагдсан байдаг. Хилийн боомтуудын талаар:Хилийн асуудлаар хөрш улсуудтай байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ болон Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу улсын хилд нийт 52 боомт ажиллахаас өнөөгийн байдлаар 24 боомт ажиллаж байна. Үүнд:

а. “Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1994 оны хэлэлцээр”-ийн дагуу Монгол, Оросын хилд авто замын 27, төмөр замын 2, нийт 29 боомт

<sup>1</sup> Монгол Улсын Шинэ сэргэлтийн бодлого, 2021.12.30. МУИХ-ын тогтоол Д/106

<sup>2</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010.07.15. заалт 3.1.2.5.

<sup>3</sup> Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он, заалт 3.20.

<sup>4</sup> Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он, заалт 2.1.2

ажиллахаас 10 боомт ажиллаж, дэд бүтэц хөгжөөгүй, бүтээн байгуулалт хийгдээгүйн улмаас 19 боомт ажиллахгүй байна;

б. “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээр”-ийн дагуу Монгол, Хятадын хилд авто замын 13, төмөр замын 4, нийт 17 боомт ажиллахаас 13 боомт ажиллаж, 4 боомт шинээр нээхээр төлөвлөж байна;

Засгийн газрын тогтоолын дагуу агаарын замын 6 боомт ажиллахаас 1 боомт ажиллаж байна. Монгол Улсын нийт экспортын 86.5 хувийг БНХАУ-д гаргасан экспорт, нийт импортын 65.0 хувийг хоёр хөршөөс худалдан авсан импорт эзэлж байгаа нь эдгээр улсаас гадаад худалдааны хамаарал өндөр хэвээр байгаа гэсэн үзүүлэлт<sup>1</sup> юм. Цар тахлаас шалтгаалан хөрш улсуудын хилийн боомтууд улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, ачаа барааг нэвтрүүлэх үйл ажиллагаагаа тодорхойгүй хугацаагаар үе үе зогсоох, цөөн тоогоор нэвтрүүлэх зэрэг нь экспорт, импортыг гацааж, улсын эдийн засагт хүндрэлтэй асуудлыг үүсгэж байна.

Иймд улсын эдийн засгийг сэргээх гол асуудлын нэг нь хилийн боомтуудын ирээдүйн хөгжлийн асуудал юм. Энэ талаар Монгол Улсын төр засгаас дараахи бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогод “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс болон хилийн боомтуудад орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгсэл, дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ”, “Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд

тулгуурласан ухаалаг цахим гарцыг шалган нэвтрүүлэх албанд нэвтрүүлнэ.”<sup>2</sup> гэж заасан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрт “...хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн холбоо, зэвсэглэл, техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлнэ.”, “Гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.” Гэж заасан.

Хилийн “Цагааннуур”, “Булган” боомтыг “Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем”-ээр төхөөрөмжилж, хилийн боомтуудын хилийн хэсэгт хяналтын камер, хөдөлгөөн мэдрэгч дохиолол суурилуулсан.

Монгол Улс далайд гарцгүй орны хувьд боомтуудыг авто зам, төмөр зам, хурдны замаар цаг алдалгүй холбож, агаарын тээврийн салбарыг цоо шинэ шатанд гаргах зайлшгүй шаардлагатай юм.

Хилийн боомтын хүчин чадлаар дэлхийн 160 улсаас 130 дугаарт эрэмбэлэгдсэн нь анхаарал татсан асуудал болж, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичигт нэгдүгээрт хийх ажил болсон нь цаг үеэ олсон гэж үзэж байна.

Хилийн боомтуудыг хурдны замаар холбох ажлыг Алтанбулаг-Замын-Үүд боомтуудыг холбосон 987 километр хурдны замыг барихаас эхлэхээр төлөвлөгдсөн. Боомтуудын өрсөлдөх чадвар, нэвтрэх урсгалыг нэмэгдүүлэн эрс сайжруулж, боомт түшиглэсэн эдийн засгийн чөлөөт бүс болон шинэ хотуудыг байгуулахаар тооцоо судалгаа гарч байна.

<sup>1</sup> Гаалийн Ерөнхий газар, Статистикийн хэлтэс.

<sup>2</sup> “Алсын хараа-2050” Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого, Дархан хил, Зорилт 7.

Шинэ нисэх онгоцны буудлыг Ази, Европыг холбосон агаарын тээврийн дамжин өнгөрүүлэх төв болгон өргөжүүлж, агаарын тээврийн чөлөөт өрсөлдөөнийг идэвхжүүлж, дэлхийн хэмжээний иргэний болон ачаа тээврийн компаниудтай нээлттэй, харилцан ашигтай түншлэн ажиллахаар болсон.

Хилийн шалган нэвтрүүлэх албанд нэвтрүүлж байгаа орчин үеийн дэвшилтэт технологийн талаар:

“Хилийн хяналтыг явуулахад шаардлагатай барилга, байгууламж, талбай, тэдгээрийн тоног төхөөрөмжийг барьж байгуулсны дараа улсын хил хамгаалах байгууллага нь хилийн хяналтын бусад байгууллагатай хамтарч тухайн хилийн боомтыг нээж ажиллуулна.”<sup>1</sup> Гэсэн заалтаар хилийн боомт нь цаг үеийн хөгжлөө дагаж, улсын бодлогоор өргөжин тэлэх, шинэ технологид тулгуурлан үйл ажиллагаагаа явуулах шаардлагатай.

Хилийн боомтын өргөтгөл, шинэчлэлийн ажлын хүрээнд БНХАУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Замын-Үүд” боомтыг шинэчлэх, “Гашуунсухайт” боомтыг өргөтгөх, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр “Сүхбаатар”, “Боршоо”, “Бичигт” боомтыг шинэчлэх, “Алтанбулаг” боомтыг өргөтгөх ажил хийгдэж байна. Хилийн “Гашуунсухайт”, “Ханги”, “Бичигт” боомтод жолооч нарын баримт бичгийг шалгах тусгай зориулалтын 22 кабиныг суурилуулж, нэвтрүүлэх хүчин чадлыг нь нэмэгдүүлсэн.

Тус боомтуудын өргөтгөл, шинэчлэлийн ажил хэрэгжсэнээр олон улсын жишигт нийцсэн боомтууд байгуулагдаж, боомтын нэвтрүүлэх хүчин чадал, худалдаа эргэлт, эдийн засгийн үр ашиг эрс

нэмэгдэж, зорчигч 4, ачаа бараа 3, тээврийн хэрэгсэл 6, агаарын замын боомтын хүчин чадал 2 дахин нэмэгдэх тооцоотой. “Зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийн програм хангамжийг сайжруулж, 30 удаагийн шинэчлэл, хөгжүүлэлт хийсэн.

“Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн дагуу улсын хил нэвтрэх гадаадын иргэнийг биеийн давхцахгүй өгөгдөл /биометр мэдээлэл/-өөр бүртгэх үйл ажиллагааг хилийн боомтуудад нэвтрүүлж эхэлсэн. Хилийн боомтын хөгжлийн асуудал нь улсын эдийн засагт шууд тусгалаа үзүүлдэгийг дэлхий нийтээр цар тахалд нэрвэгдсэн энэ цаг үед улс орнуудад илүү мэдрэгдэж байна.

### Дүгнэлт

Монгол Улсын Засгийн газраас Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг 2022 онд бүрэн ашиглалтад оруулж, Ханги, Бичигт, Шивээхүрэн, Арцсуурь боомтуудыг төмөр замаар холбох ажлыг цаг алдалгүй шуурхай эхлүүлэхээр ажиллаж байна. Энэхүү ажлыг гүйцэтгэснээр 5600 орчим километр урттай үндэсний төмөр замын сүлжээ бий болж, цаашид “Транзит Монгол Улс” болох суурь нөхцөл бүрдэхээр харагдаж байна. Цар тахлын хүнд хэцүү энэ цаг үед хилийн боомтоор нэвтрэх экспорт, импортын асуудал гадаад улсын талаас шууд хамаарч байгаа нь Монгол Улсын эдийн засагт хүндрэл учруулж байна. Энэхүү тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэхэд Хил хамгаалах байгууллага шат, шатандаа хилийн хяналтын болон бусад харилцан ажиллагаатай байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, төр, засгийн холбогдох яам, агентлаг, Улсын онцгой комисс,

<sup>1</sup> Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг.

Хилийн боомтын үндэсний зөвлөлтэй ажлаа уялдуулан ажиллаж байна.

### **Санал**

Нэг. Хилийн боомтын хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад идэвх, санаачлагатай баг оролцуулж, хөгжлийн зурагт багтсан томоохон боомтуудад хилийн хяналтын байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай орчин үеийн техник технологийн нэгдсэн системийн хөгжүүлэлт хийх;

Хоёр. Хилийн боомтын барилга байгууламжийн асуудлыг шинэчлэхийн зэрэгцээгээр алба хаагчдын амьдрах орон байрны асуудлыг шийдвэрлэх зураг төсөл, холбогдох тооцоо судалгааг улсын төсөвт суулгуулах;

Гурав. Хилийн боомтын хөгжлийн асуудлыг дагаад Хил хамгаалах байгууллагын Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх алба, Ар тал, хангалт үйлчилгээг хариуцсан чиглэлийн бүтэц, ажил үүргийн хуваарьт өөрчлөлт оруулах;

Дөрөв. Гадаадын улс орнуудын хөгжсөн жишиг хилийн боомтуудын

туршлагыг хөгжлийн төлөвлөлтдөө тусган хэрэгжүүлэх;

Тав. Шинэ сэргэлтийн 6 багц асуудал нь хоорондоо уялдаа холбоотой асуудал бөгөөд улсын хилийн орон зайн хөгжлийн гарц гэж харж, алсыг харсан томоохон шийдлийг хөгжлийн зурагт уялдуулах, асуудлыг шийдвэрлүүлэх зэрэг болно.

### **Эх сурвалжийн жагсаалт**

- Монгол Улсын “Шинэ сэргэлтийн бодлого” 2021 он.
- Монгол Улсын Хилийн тухай хууль, 2017 он.
- “Алсын хараа-2050” Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны хөгжлийн бодлого, Дархан хил, Зорилт 7.
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010 он.
- Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011 он.
- Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, 2002 он.